

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2017 оны 06 сарын 01-ний өдөр “Баясгалантай бага нас” урлагийн тоглолтыг сумын Соёлын төвтэй хамтран зохион байгуулсан. Тус тоглолтонд 87 авьяаслаг хүүхдүүд мэндчилгээ дэвшүүлж, урлагийн номеруудаа үзүүллээ.



Тоглолтын эхэнд аймгийн ИТХ-ын дарга Г.Батзандан, сумын удирдлагууд Б.Соёлмаа, Ө.Урнаа, Ч.Энхжаргал, С.Минжбадгар, Д.Эрдэнэ, Д.Уянга нарын 6 эхэд Алдарт эхийн II зэргийн одон гардуулж, сумын Ахмадын хорооноос Ш.Лхамсүрэн, М.Дарьсүрэн, М.Хишигдэлгэр, Н.Цогзолмаа, Д.Болд, Ж.Рэнцэндулам нарыг “Хаан аав, хатан ээж” –ээр шалгаруулж, өргөмжлөл гардууллаа.



Тоглолтын үеэр хүүхдийн эрхийг сурталчлах үзүүлэн самбар байршуулж, төсвийн байгууллагуудтай хамтран хөгжөөнт тоглоомыг үзэгч хүүхдүүдийн дунд зохион байгуулсан. Үүнд:

Эрүүл мэндийн төв – АХА хөгжөөнт тэмцээн

3-р сургууль – Гар зургийн уралдаан

3-р цэцэрлэг – Азын бөмбөлөг

ЗДТГ – Унадаг дугуйн уралдааныг тус тус зохион байгуулж, хамтран ажиллалаа.



Тоглолтонд оролцсон 57 хүүхэд, сумын зорилтот бүлгийн 61 хүүхдэд ШОХК-ийн удирдлагууд бэлэг гардуулж, хамтран ажиллалаа.